



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар A/62

Өвт

Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.4.5 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Бат-Өлзий суманд бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулахтай холбогдуулан 2022 оны 04 дүгээр сарын 20-оос 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрүүдийг хог цэвэрлэгээний өдөр болгож, дээрхи өдрүүдэд бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсугай.

2. Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажилд аж ахуйн нэгж, албан байгууллагуудын орчин, айл өрхийн хашаа, гудамж, нийтийн эзэмшлийн болон нэгдсэн хогийн цэгийн талбайг цэвэрлүүлэн, хогийг нэгдсэн цэгт ангилан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг албан байгууллагуудын дарга, эрхлэгч (Н.Бат-Эрдэнэ, Б.Ууганчимэг, Н.Батжаргал, Ж.Тогоохүү, Д.Очирбат, Х.Цэдэндорж), багийн Засаг дарга (Ж.Нямтготох, Д.Бямбасүрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Л.Балжиняа, Д.Дэмиддагва) нарт үүрэг болгосугай.

4. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг иргэдийг нийтийн эзэмшлийн газар, голын голдирогын ойролцоо хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх ажилд бүртгэн, цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн ажилтан (Н.Долгормаа), (багийн Засаг дарга нар, Ерөнхий боловсролын сургуулийн захирал) нарт даалгасугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрд авч нэгдсэн удирдлагаар хангаж, тайланг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Засаг даргын орлогч (Н.Орхонтуул), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Янжиндулам) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

622201129

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)
- Гишүүд: Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)
- Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
- Д.Энх-Амгалан (Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад)
- Б.Ууганчимэг (Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан  
тушаалыг түр орлон гүйцэтгэгч)
- Х.Цэдэндорж (Эрүүл мэндийн төвийн дарга)
- Д.Очирбат (Соёлын төвийн эрхлэгч)
- Д.Очирхуяг (Ойн ангийн дарга)
- Н.Батжаргал (1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч)
- Ж.Тогоохүү (2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч)
- С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)
- Л.Балжинням (5 дугаар багийн Засаг дарга)
- Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)
- Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
- Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)
- Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)
- И.Маралмаа (Газрын даамал)
- Н.Түвшин (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
- Н.Долгормаа (Нийгмийн ажилтан)
- Б.Энхмаа (Байгаль хамгаалагч)
- Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)
- Н.Пүрэвтогтох (Байгаль хамгаалагч)
- Г.Бямбагарав (ТӨҮК-ны захирал)